



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 12 сарын 10 өдөр

Дугаар 504

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Сүхбаатар аймаг дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, сэргээн засварлах боломжгүй болсон нийт 7,450,000.00 /долоон сая дөрвөн зуун тавин мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий 1 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Өнөрбаяр, Сүхбаатар аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Д.Гантулга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримтын хамт 2020 оны 2 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ВҮЙН,
ХЭЛТСИЙН ДАРГА

А.АРИУНБОЛД



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн
508 дугаар тогтоолын хавсралт

Сүхбаатар аймаг дахь Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн үндсэн хөрөнгөд
бүртгэлтэй нээлттэй дуудлагын худалдаагаар худалдах автомашин

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Саргаан босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Дэнчингийн хэмжээ (төгрөг)
1	Верна аксент, 40-74 СУА, арал № КМНСГ41FP1U265526	2005/ 2011	216585	7,450,000.00	7,450,000.00	0	0	500,000.00	125,000.00
	Нийт дүн			7,450,000.00 /долоон сая дөрвөн зуун тавин мянган/	7,450,000.00 /долоон сая дөрвөн зуун тавин мянган/	0	0	500,000.00 /таван зуун мянган/	125,000.00 /нэг зуун хорин таван мянган/